

БАТЛАВ:

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДЭД ДАРГА**



Б.САРУУЛ

**ХҮҮХДИЙН БАЯР БУЮУ ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ
ӨДРИЙГ УГТСАН “ЕРӨНХИЙЛӨГЧИД ХҮРГЭХ МИНИЙ ҮГ” АЯНЫ УДИРДАМЖ**

Зохион байгуулагч: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, “Гүүд Нэйборс” ОУТББ-ын Монгол дахь төлөөлөгчийн газар, Сургуулийн Нийгмийн ажилтнуудын нийгэмлэг.

Зорилго: Хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эрхийг дэмжих, нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн санал, санаачилгыг хүргэхэд оршино.

Хүрэх үр дүн:

1. Хүүхдүүд санал бодлоо илэрхийлэх аргад суралцана.
2. Төр, олон нийт хүүхдийн дуу хоолойг сонсож, хүүхдийн санал бодлыг шийдвэр гаргахдаа анхаарч тусгадаг соёл, хандлага төлөвшихөд нөлөө үзүүлнэ.

Аяны үргэлжлэх хугацаа: 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс 25-ны өдөр хүртэл.

Хамрах хүрээ: 6-18 хүртэлх насны хүүхдүүд.

Захидалд тавигдах шаардлага:

- Захидлын агуулга нь улс орны болон орон нутгийн хөгжил дэвшилд хувь нэмэр болохуйц шинэ санаа, санаачилгыг илэрхийлсэн, хүүхдийн өөрийн хүсэл мөрөөдөл, тулгамдаж буй асуудлын талаар зэрэг ямар ч агуулгатай (хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, боловсрол, чөлөөт цагийн орчин, хүүхдийн эрх, хамгаалал, ундны ус, орчны эрүүл ахуй, агаарын бохирдол, орон нутгийн хөгжил, гэр бүлийн амьдрал, хувийн үзэл бодол гэх мэт) байж болно.
- Хүүхэд өөрөө сайн дурын үндсэн дээр захидал бичих;
- Хүүхдийг захидал бичих явцад захидлын утга санаа, агуулгад хэн нэгэн насанд хүрэгч нөлөөлөхгүй байх (багш, эцэг эх, бусад);
- Захидлыг А4 (21x29.7 см) хэмжээтэй цаасны нэг нүүрт багтаан, өөрийн гараар бичиж, зориулалтын дугтуйнд хийж битүүмжилсэн байх;
- Захидал бичсэн хүүхдийн овог нэр, харьяа сургууль, анги, бүлэг, нас, холбоо барих утасны дугаар (хүүхэд, эцэг эх, анги удирдсан багшийн), цахим хаяг (Facebook, e-mail хаяг г.м)-ийг бичсэн байх. Хүүхэд сургуульд сурдаггүй бол гэрийн хаягаа бичсэн байх.

Гар зурагт тавигдах шаардлага:

- Хүүхэд захидалд тавигдах агуулгыг багтаасан өөрийн санаа бодлоо гар зургаар илэрхийлж болно.
- Гар зургийн бүх төрлөөр, А3 (42x29.7 см) хэмжээгээр зурсан байх;
- Бүтээл нугаларч гэмтээгүй байх;
- Зураг зурсан хүүхдийн овог нэр, харьяа сургууль, анги, бүлэг, нас, холбоо барих утасны дугаар (хүүхэд, эцэг эх, анги удирдсан багшийн утасны дугаар), цахим хаяг (Facebook, e-mail хаяг г.м)-ийг болон зургийн тайлбарыг бичсэн байх. Хүүхэд сургуульд сурдаггүй бол гэрийн хаягаа бичсэн байх.

Захидал болон зургийг хүлээн авах:

- Хүүхдүүдийн бичсэн захидал, зурсан зургийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс 5 дугаар сарын 25-ны өдрийн хооронд хүлээн авна.
- Захидал болон зургийг “Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга Танаа” гэж хаяглан, ойролцоох шуудан холбооны газарт очиж шуудангаар илгээнэ.
- Сургууль дээр сургуулийн нийгмийн ажилтан хүүхдүүдийн бичсэн захидлыг хүлээн авч, нэгдсэн байдлаар шуудангаар илгээнэ.

Жич: 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс хойш ирүүлсэн захидал, зургийг хүлээж авахгүйг анхаарна уу.

Аяны үр дүнд авах арга хэмжээ:

1. Хүүхдийн баяр буюу олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан захидал бичих энэхүү аянд идэвхтэй оролцон, үзэл бодлоо зөв зохистой илэрхийлж, үе тэнгийнхнийхээ дуу хоолой болж чадахуйц шаардлага хангасан захидал болон зураг илгээсэн 100 хүүхэд 2018 оны 6 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчтэй биечлэн уулзах уулзалтад оролцоно.
2. Хүүхдүүдийн бичсэн захидал, зурсан зургаар үзэсгэлэн гаргаж, олон нийтийн хүртээл болгоно.
3. Хүүхдийн шинэ санал, санаачилгыг нэгтгэн хэвлэн нийтэлж, олон нийтэд түгээнэ.
4. Зарим санал санаачилга, тулгамдаж буй асуудлуудыг төр засгийн бодлогод тусгуулах нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна.

---o0o---